

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА,
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
2019 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2019.12.20

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	ЗДТГ	ИТХТ
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
1	1.1. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг тус тус аймаг орон нутагт хангуулах, төрийн байгууллагын удирдлагын хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх.	1.1.1. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрмийг шинэчлэн боловсруулан батлуулж цахимд байршуулах.	Аймгийн цахим сайтын хүний нөөцийн ил тод байдал цэсний ёс зүйн дүрэмд холбогдох журам, дүрэм, ёс зүйн мэдээг байршуулсан.	100.0	100.0
		1.1.2. Төрийн албаны тухай хуульд зааснаар хүний нөөц, сургалттай холбоотой баримт бичгүүдэд зохих нэмэлт оруулах, шинэчлэн	Аймгийн Засаг даргын 2017 оны а/525 захирамжаар батлагдсан “Төрийн албан хаагчдын сургалт-хөгжил” аймгийн хөтөлбөрийн хүрээнд Төрийн албаны тухай хууль тогтоомж, төрийн албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, сахилга, хариуцлага, ёс зүй, манлайллыг сайжруулах, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгтэй холбогдуулан	100.0	100.0

	боловсруулах зэрэг ажил арга хэмжээ авах.	<p>төрийн албан хаагчдыг чадавхижуулах, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, мэргэшүүлэх хүрээнд 2019 оны сургалтын төлөвлөгөөг батлуулсан.</p> <p>Дээрх төлөвлөгөөний хүрээнд 2019 оны байдлаар нийт давхардсан тоогоор 10636 төрийн албан хаагчийг хамруулсан. Үүнээс доктронтурт 1 албан хаагч, магистрийн зэрэг олгох сургалтад 51 албан хаагч, бакалаврын зэрэг олгох сургалтад 15 албан хаагч, гадаад оронд зохион байгуулагдсан сургалтад 38 албан хаагч тус тус хамрагдсан. Төрийн албан хаагчдыг чадавхижуулах, мэргэшүүлэх, мэргэжил олгох, сургалт хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд зориулж нийт 134.6 сая /улс, орон нутгийн төсөв/ төгрөгийг сургалт хөгжлийн арга хэмжээнд зарцуулжээ.</p>		
	1.1.3. Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх ажлын хүрээнд шинэчилсэн найруулгаар батлагдсан Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, удирдах албан тушаалтан болон төрийн албан хаагч нарт сургалт, сурталчилгаа зохион байгуулах.	<p>Төрийн үйлчилгээний удирдах болон төрийн захиргааны албан тушаалтны албан тушаалын тодорхойлолтын боловсруулалтыг хянах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2019 оны А/200 дугаар захирамжаар байгуулж, чиг үүргийн болон ажлын байрны шинжилгээ хийх, албан тушаалын тодорхойлолт боловсруулах чиглэлээр Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран сургалт зохион байгуулж, 240 гаруй төрийн албан хаагчдыг хамрууллаа.</p> <p>Аймгийн хэмжээнд төрийн захиргааны 29 байгууллагын нийт 163 албан тушаалд хамаарах 103 албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан, Төрийн албаны зөвлөлөөр хянуулж, баталгаажуулан ажиллаж байна. Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалд хамаарах 11 албан тушаалын тодорхойлолтыг хянуулж, санал авахаар Төрийн албаны зөвлөлд хүргүүлснээс Ерөнхий боловсролын сургуулийн захирал, Цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалын тодорхойлолтыг баталгаажуулсан.</p>	100.0	100.0
	1.1.4. Төрийн албанд ажиллаж буй тэтгэвэртээ гарсан болон 2019 онд	Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу өндөр настны тэтгэвэр тогтоолгох насанд хүрч төрийн албанаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний 8 албан хаагчид 141.3 сая, боловсрол,	100.0	100.0

		тэтгэвэрт гарах албан хаагчдын судалгааг гаргаж хуулийн дагуу зохих арга хэмжээ авах.	соёл, урлагийн салбарын 49 хүнд 676.7 ая төгрөгийн, эрүүл мэндийн салбарын 24 хүнд 395.4 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус хууль тогтоомжийн дагуу олгосон.		
		1.1.5. 5-аас доошгүй сумыг сонгон Засаг даргын Тамгын газрын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө түүний хэрэгжилт, албан тушаалтнуудын ХАСУМ болон ХАСХОМ бүрдүүлэх үйл ажиллагаатай биечлэн танилцах, эрх бүхий албан тушаалтны (ЭБАТ) үйл ажиллагаанд тус тус хяналт шалгалт явуулах.	<p>Аймгийн Засаг дарын Тамгын газрын ЭБАТушаалтны харьяа нэгж, байгууллагын 25 эрх бүхий албан тушаалтны ХАСУМ болон ХАСХОМ бүрдүүлэх үйл ажиллагаанд цахим системээр жилийн турш тогтмол хяналт тавьж, хугацаа хоцорсон 2, мэдүүлэгчийн баталгаажилт болон ЭБАТ-ны баталгаажилт хийгдээгүй 5 мэдүүлгийг нөхөн баталгаажилтийг хийлгэн, зөрчлийг арилгуулсан.</p> <p>Шинээр томилогдсон 3 ЭБАТ-ны үйл ажиллагаанд анхаарч, холбогдох заавар журам, хичээл, гарын авлагыг цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлэн, заавар зөвлөмжөөр ханган ажиллав.</p> <p>Тус аймагт 2019 оны 10 дугаар сард зохион байгуулагдсан АТГ-ын сургалтад 19 сум, 21 байгууллагын ЭБАТушаалтнуудыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулсан</p>	70.0	70.0
ДУНДАЖ ОНОО				94.0	94.0
Хоёр. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар хүлээсэн төрийн байгууллагын нийтлэг үүрэг					
	2.1. Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1. Улсын Их Хуралд хэлэлцэгдэх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо, нөхцөлөөр хангах.	2.1.1. Үйл ажиллагаандаа ашиглаж буй аймгийн албан ёсны цахим хуудас www.uvurkhangaï.mn сайтыг өргөтгөн шинэчлэх. Хэлэлцэгдэж буй хууль, шийдвэрийн төсөлд төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийтийн зүгээс	<p>“Ай Ти Солушинс” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, аймгийн албан ёсны цахим хуудас www.uvurkhangaï.mn сайтад шаардагдах 660.0 мянган төгрөгийн засвар үйлчилгээ хийж, хөгжүүлэлтийг сайжруулав.</p> <p>Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж буй хуулийн төсөл, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлд иргэд олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагууд саналаа илэрхийлэх нөхцөлийг нэмэгдүүлэх зорилгоор УИХ-ын “Цахим хэлэлцүүлэг” цэсийг www.uvurkhangaï.mn сайтын “Төрийн үйлчилгээ” хэсэгт үүсгэж, тогтмол баяжуулж ажиллав.</p>	100.0	100.0

		санал, хүсэлт илэрхийлэх бололцоог нэмэгдүүлэх.			
	2.1.2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүд хариуцсан салбарын чиглэлээр боловсруулагдаж буй Хуулийн төсөл, Улсын Их Хурал, Засгийн газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсанд байршуулж, иргэд, олон нийт сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авах ажлыг зохион байгуулж, хийгдсэн ажлаа тухай бүр цахим хуудсанд байршуулж мэдээлэх.	<p>Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж буй хуулийн төсөл, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлд иргэд олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагууд санал бодол, дуу хоолойгоо илэрхийлэх нөхцөлийг бий болгож УИХ-ын “Цахим хэлэлцүүлэг” цэсийг www.uvurkhangai.mn сайтын “Төрийн үйлчилгээ” хэсэгт үүсгэв. Мөн аймгийн аймгийн ИТХ-аар батлуулж буй бодлогын баримт бичиг, захиргааны хэм хэмжээ тогтоосон 2 актын төслийг цахим хуудсанд байршуулж, улмаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийтийн зүгээс 891 санал, хүсэлтийг хүлээн авч, үйл ажиллагаандаа тусган ажиллав.</p> <p>2019 онд аймгийн Засаг даргаас захиргааны хэм хэмжээ тогтоосон 1 шийдвэр /24 цагаар хүнс, ахуйн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн худалдаалах/ гарсаныг Хууль, зүйн дотоод хэргийн яаманд бүртгүүлэхээр хүргүүлээд байна. Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/02 дугаар тогтоолоор “Тариф батлах тухай” 11/01 дүгээр тогтоолоор “Журам батлах тухай”, 11/02 дугаар тогтоолоор “Тариф батлах тухай” тогтоолыг тус тус баталсныг, бусад холбогдох баримтуудын хамт бүрдүүлбэрийг ханган Хууль зүй, дотоод хэргийн яамны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр ажиллаж байна.</p> <p>“Жендэр-өв дэд хөтөлбөр”-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 13 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж, уг хөтөлбөрийн төслийг цахим сайтад байршуулж, жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны үйл ажиллагааг ХЭҮК болон орон нутгийн хэвлэл мэдээлэл цахим хуудсаар тус тус тухай бүр нь мэдээлсэн.</p>	100.0	100.0	
2.2. Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2. Төрийн байгууллага Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд	2.2.1. Байгууллагын цахим хуудсанд авлигын эсрэг 2019 оны төлөвлөгөө, иргэд болон хувийн ашиг	Байгууллагын буюу аймгийн нэгдсэн цахим хуудас www.uvurkhangai.mn сайтны “Ил тод” цэсэнд “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” хэсэг нэмж үүсгэн, авлигын эсрэг 2019 оны төлөвлөгөө, өмнөх оны буюу 2018 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний	100.0	100.0	

<p>сурталчилах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах.</p>	<p>сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудад зориулсан шаардлагатай гарын авлага, тараах материал бусад мэдээллийг бэлтгэн байршуулах.</p>	<p>хэрэгжилт, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудад зориулсан ХАСУМ, ХАСХОМ маягтуудыг тус тус татаж авах боломжтойгоор байршуулав. Мөн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлаа тухай бүр дээрх цэсний цаг үеийн мэдээлэл хэсэгт оруулж, бусад шаардлагатай гарын авлага, тараах материал зэрийг тус тус бэлтгэн байршуулсан.</p>		
	<p>2.2.2. Авлигын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиудаар иргэдэд сургалт мэдээлэл өгөх, гарын авлага, шторкыг олон нийтийн сүлжээгээр тараах.</p>	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх чиглэлээр төрийн байгууллагын бүх шатанд зохион байгуулалтын арга хэмжээг авч, иргэдийг мэдээ мэдээллээр хангах үйл ажиллагаа тогтмолжсон. Тайлант онд сум, агентлагууд давхардсан тоогоор нийт 78 удаагийн сургалтаар 3000 орчим төрийн албан хаагч болон иргэдийг сургалтад хамруулж, 3200 гаруй гарын авлага тараах материал тараасан байна. Аймгийн цахим хуудас www.uvurkhangai.mn/, болон Өвөрхангай аймаг фейсбүүк пэйж хуудас, бүх сум, төрийн байгууллагууд цахим хуудсаараа дамжуулан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон бусад цаг үеийн мэдээ мэдээллийг нийтэд мэдээлж байна.</p>	70.0	70.0
<p>2.3. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3. Төрийн хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах.</p>	<p>2.3.1. Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын нэгжийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах.</p>	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг нийт 5 зорилтын хүрээнд 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллав. Үйл ажиллагааны хэрэгжилт үр дүнг хагас жил тутам дүгнэн ажилласан бөгөөд жилийн эцсийн байдлаар 93.2 хувийн хэрэгжилттэй байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс байгууллагын дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 10 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгаж, хэрэгжилтийн ханган ажилласан бөгөөд хэрэгжилт үр дүнг нэгтгэн дүгнэлээ.</p>	100.0	100.0
	<p>2.3.2. Хяналт</p>	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ,</p>	100.0	100.0

	шинжилгээ үнэлгээний талаарх мэдээллийг аймгийн цахим хуудсанд тогтмол байршуулж, иргэдийг мэдээллээр хангах.	үнэлгээний нэгжийн төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг тусгайлсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу хэрэгжүүлж, зөвлөмж, арга зүйгээр хангах, зөвлөн туслах ажлыг хэрэгжүүлж ажиллав. Хяналт-шинжилгээний удирдамж, төлөвлөгөө, үр дүнг аймгийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны цахим хуудсанд мэдээлж хэвшээд байна. 2019 оны байдлаар 19 сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх 22 агентлагийн жилийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ хийж, тусгайлсан удирдамжийн хүрээнд Нарийнтээл, Богд, Баруунбаян-Улаан сум, 3 агентлагийн үйл ажиллагаанд явцын болон үр дүнгийн хяналт-шинжилгээ хийж зөвлөмж, арга зүйгээр ханган ажиллав. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын хэрэгжүүлсэн үйл ажиллагааны мэдээг сар бүр нэгтгэн аймгийн цахим хуудсанд байршуулан иргэдийг мэдээллээр ханган ажиллаж байна.		
	2.3.3. Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны хяналт шалгалтын үйл ажиллагааг ил тод нээлттэй болгох.	Тус алба нь вэб сайтдаа 2019 онд хийгдэх хяналт шалгалт, дотоод аудит хийх төлөвлөгөө, шилэн дансны үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалт, 2019 оны хагас жилийн байдлаар сумдын сум хөгжүүлэх сангийн 2018 оны санхүүгийн үйл ажиллагаа болон байгууллагуудын 2018 оны санхүүгийн баримтанд хяналт шалгалт хийсэн мэдээлэл мөн 19 сумын сум хөгжүүлэх сан, байгууллагын 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн бөгөөд 2018 оны санхүүгийн шалгалтын дүн мэдээллийг тус тус тухай бүр мэдээлсэн байна. Нийт 70 орчим мэдээллийг байршуулсан байна.	100.0	100.0
2.4. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4. Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх.	2.4.1. Тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл болон төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухай бүр цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулах.	Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагууд төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, мэдээ тайланг байгууллагын мэдээллийн самбар, цахим хуудас, Засгийн газрын www.Shilendans.gov.mn сайтуудад байрлуулж, судалгаа шинжилгээнд ашиглах боломжтойгоор байршуулж хэвшсэн. Энэ нь иргэдэд тухай бүр үнэн зөв мэдээллээр бүрэн хангах нөхцөл бүрдэж байна. Сангийн яам, хяналт, шалгалтын байгууллагуудаас хийгдсэн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн зөвлөмж, анхааруулгыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажиллав. Тайлант хугацаанд	100.0	100.0

		шилэн дансны мэдээлэлтэй холбоотой гомдол, санал иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирээгүй болно. 2019 оны төсвийн зарлагын хэтрэлт, хэмнэлтийн мэдээ, тайлан, өр авлагат дүн шинжилгээ хийж, төсвийн зардлын бүлгийн шилжүүлгийг баримт бүрдүүлэн хийх болон сумын санхүүгийн дэмжлэгт өөрчлөлт оруулах төслийн санал оруулан танилцуулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тогтоолоор батлууллаа. Холбогдох материалыг шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбар, веб хуудас, иргэдэд мэдээллээр үйлчлэх төвд хүргүүлэн ажиллаж хэвшсэн.		
	2.4.2. Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох. (татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл) Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарын хамт мэдээлэх.	2019 оны төсвийн орлого бүрдүүлэлтийг 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар мэдээлэхэд татварын болон татварын бус орлого 11.9 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 12.9 тэрбум төгрөг төвлөрч, орлого 1.0 тэрбум төгрөгөөр давсан үзүүлэлттэй байна. Аймгийн татварын болон татварын бус орлогоос хүү торгууль, бусад орлого 41.9-47.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Сумын орлого нийт дүнгээрээ биелэсэн харагдаж байгаа боловч хөрөнгө борлуулсаны орлого, галт зэвсгийн албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, хог хаягдлын хураамж, ойн нөөц ашигласны хураамж, түгээмэл ашигт малтмал ашигласны албан татварын биелэлт 28.2-78.2 хувийн гүйцэтгэлтэй гарсан.	100.0	100.0
	2.4.3. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг нийтэд мэдээлэх.	Аймгийн төрийн аудитын газраас 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайланд аудит хийн, “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар 2 заалт бүхий албан шаардлага ирүүлсэн. Уг шаардлагын хүрээнд тодорхой ажлуудыг хэрэгжүүлж, биелэлтийн талаарх мэдээллийг www.uvurkhangai.mn сайт, байгууллагын ил тодын мэдээллийн самбарт байршуулан, нийтэд мэдээлсэн.	100.0	100.0
	2.4.4. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хуваарилалт, хэрэгжилтийн талаарх мэдээллийг и ө и ө	Эрүүл мэнд, хөдөө аж ахуйн чиглэлээр тайлант хугацаанд нийт 1.6 тэрбум төгрөгийн 11 төсөл, хөтөлбөр хэрэгжсэн байна. Тухайлбал Япон улсын “Жайка” ОУБ-ын 34.2 сая төгрөгийн санхүүжилтээр “Өвсний үндэс” төсөл болон “Орон нутгийн газар тариалан эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн агро бизнесийг хөгжүүлэх” төсөл,	100.0	100.0

	í èèòýä нээлттэй õ¿ðãýõ, цахим хуудсанд байршуулж хэвших.	Дэлхийн Зөн Олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа “Өрхийн хөгжил-320” төсөл, Зах зээл ба бэлчээрийн удирдлага төслийн хөрөнгөөр инженерийн хийцтэй 4 худаг шинээр гаргаж, мал угаалгын банн 4 ширхэг, Арвайхээр сумын төв бараан захад 15 павилоныг барьж тус тус хүлээлгэн өгсөн. Эрүүл мэндийг дэмжих сан, Глобаль сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр сүрьеэгийн явуулын үзлэгийн баг 18 сум, уул уурхайн олборлолт хийж буй 2 багт хүрч, сүрьеэгийн эрт илрүүлгийн үзлэгийг 5784 хүнд хийсэн гэх мэт төсөл, хөтөлбөрүүд амжилттай хэрэгжсэн бөгөөд дээрх төсөл, хөтөлбөрийг тухай бүрт нь харицусан салбарын байгууллагууд байгууллагын болон аймгийн нэгдсэн сайтад байршуулж, ил тод мэдээлж ажилласан байна.		
2.5. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5. Тухайн байгууллагын чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол олон нийтэд ил тод байлгаж, түүнтэй танилцах боломжоор хангах.	2.5.1. Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, холбогдох хууль тогтоомжийг сайтад байршуулан олон нийтийг танилцах боломжоор хангах.	Аймгийн вэб сайтад байршуулах Салбар зөвлөлийн үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлын цэсийг “Төрийн байгууллагын вэб сайтад тавигдах шаардлага MNS 6285:2016, MNS 6285:2017” стандартын дагуу шинэчлэн, мэдээллийг бүрэн оруулж иргэд, олон нийт мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.	100.0	100.0
	2.5.2. Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан, ил тод байдлыг хангаж ажиллах.	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын дагуу төрийн үйлчилгээний удирдах 11 албан тушаалын сонгон шалгаруулалтыг зарлаж, шалгалтад тэнцсэн Арвайхээр сумын ерөнхий боловсролын Тэмүүлэл-Эрдэм сургуулийн захирал, Хархорин сумын ерөнхий боловсролын Гүнзгий сургуулийн захирал, Хужирт сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал, Нарийнтээл сумын Баянтээг багийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, Арвайхээр сумын	70.0	70.0

			10 дугаар цэцэрлэгийн эрхлэгч нарыг Салбар зөвлөлөөс нэр дэвшүүлж, урьдчилсан мэдүүлгийг хянуулан дүгнэлт гаргуулан, тухайн өрсөлдсөн албан тушаалд томилсон. 2019 оны 12 дугаар сард төрийн үйлчилгээний байгууллагын 8 төсвийн шууд захирагчийн сул тооны зар, төрийн захиргааны албан тушаалын 110 сул орон тооны судалгааг гарган, Төрийн албаны зөвлөлд хүргүүлээд байна.		
		2.5.3. “Аймгийн худалдаа, үйчилгээний цэгүүдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”, бүрдүүлэх материал, тусгай зөвшөөрөл олгосон иргэн, аж ахуйн нэгжийн дэлгэрэнгүй мэдээллийг тухай бүр цахим хуудсанд байршуулах.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 07/05 дугаар тогтоолоор батлагдсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хяналт тавих журам”-ыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 3892 дугаарт бүртгүүлэн, аймгийн хэмжээнд хүчин төгөлдөр дагаж мөрдөн ажиллаж байгаа бөгөөд журмын хэрэгжилтийг орон тооны бус зөвлөлөөр тухай бүр хэлэлцэж, үр дүнг тооцон ажиллаж байна. 2019 онд тусгай зөвшөөрлийн орон тооны бус зөвлөл 5 удаа хуралдаж, 233 цэгт сунгалтаар, 4 цэгт шинээр тусгай зөвшөөрөл олгож, тусгай зөвшөөрөл олгосон иргэн, аж ахуйн нэгжийн дэлгэрэнгүй мэдээллийг тухай бүр “Uvurkhangai.mn” цахим хуудасны тусгай зөвшөөрөл цэсэнд байршуулж хэвшсэн.	100.0	100.0
		2.5.4. Эрүүл мэнд болон боловсролын салбарын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбогдох хууль, журам болон тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын жагсаалт, олгосон тусгай зөвшөөрөл зэргийг тус тус сайтад байршуулж, нийтэд мэдээлэх.	Эрүүл мэнд болон боловсролын салбарын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбогдох хууль, журам болон тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын жагсаалт, олгосон тусгай зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээллийг www.uvurkhangai.mn сайт болон БСУГ, ЭМГ-ын цахим хуудсанд тогтмол байршуулж, мэдээлэл авах боломжоор ханган ажиллав. 2019 онд эрүүл мэндийн 13 байгууллагад шинээр тусгай зөвшөөрөл олгож, 26 байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгасан бол боловсролын салбарт сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг нийт 14 байгууллагад олгосноос 11 байгууллагад шинээр олгож, 3 байгууллагын сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгасан байна.	100.0	100.0
		2.5.5. Уул уурхай,	Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон	100.0	100.0

		байгаль орчин, газрын харилцааны салбарт олгогдож байгаа тусгай зөвшөөрөлтэй холбоотой хууль, журам болон тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын жагсаалт, олгосон тусгай зөвшөөрөл зэргийг тус тус сайтад байршуулж, нийтэд мэдээлэх.	ашиглалтын тусгай зөвшөөрөл авахад тавигдах шаардлага, тусгай зөвшөөрөл сунгуулахад бүрдүүлэх материал, 2019 онд олгосон 2 хайгуулын тусгай зөвшөөрлийн жагсаалтыг аймгийн нэгдсэн цахим хуудас www.uvurkhangai.mn сайтад байршуулав.Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдоогүй байна.		
2.6. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10. Төрийн байгууллагаас гаргасан шийдвэр иргэд болон бусад сонирхогч талуудад ойлгомжтой, нээлттэй байх.	2.6.1. Аймгийн Засаг даргын захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын тушаалын нууцад хамааруулснаас бусад шийдвэрийг цахим хуудаст байршуулж нийтэд ил тод мэдээлэх	Аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын байдлаар үйл ажиллагааны 745, боловсон хүчний 44 захирамжийн төсөлд шийдвэр гаргах хяналтын дагалдах хуудсаар үйлчилгээ үзүүлж, хууль тогтоомжид нийцүүлэх, архив албан хэрэг хөтлөлтийн стандартыг хянаж, хувийн хэргийг бүрдүүлэн, баталгаажсан шийдвэрийг бүртгэж, аймгийн www.uvurkhangai.mn цахим сайтад сар бүр байршуулан иргэдэд ил тод мэдээлэх ажил тогтмолжсон.	100.0	100.0	
	2.6.2. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж (хуульчилсан акт) дүрэм, журам, заавар болон төлбөрт үйлчилгээний жагсаалтыг цахим хуудсандаа байршуулах.	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Архивын тасгийн төлбөрт үйлчилгээний жагсаалт гэх мэт байгууллагуудын үйл ажиллагаандаа мөрдөж буй хууль, тогтоомж, дүрэм журам, шийдвэрүүдийн жагсаалтыг аймгийн албан ёсны цахим хуудасны “Ил тод” цэсэнд байршуулав. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдээс цахим хуудсанд байршуулах, мэдээллүүдийн жагсаалтыг гаргаж бодлогын хэлтсийн хариуцсан мэргэжилтнүүдээс тухай бүр мэдээллийг авч байршуулан олон нийтэд мэдээлж байна.	100.0	100.0	
2.7. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10. Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат	2.7.1. Өргөдөл (санал, мэдэгдэл), гомдол, хүсэлт, мэдээлэл өóóòàé хүлээн авах нөхцөлийг бүрдүүлүө.	Аймгийн хэмжээнд төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг дараах эх үүсвэрээр хүлээн авч байна. Үүнд: -Аймгийн төрийн захиргааны байгууллагууд; -Аймгийн “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн 7032-1111	100.0	100.0	

<p>дамжлагыг цөөрүүлэх энэ чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх.</p>	<p>(утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр)</p>	<p>дугаарын нээлттэй утсаар; -www.Uvurkhangai.mn болон сум, агентлагуудын цахим хуудсаар; -Агентлаг, сумдын ЗДТГ-ын “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр; -Засгийн газрын “Иргэд олон нийттэй харилцах төв”-өөр тус тус өргөдөл, гомдлыг хүлээн авч байна. Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх агентлаг, төсөвт байгууллагад 2019 оны 3 дугаар улирлын байдлаар иргэдээс нийт 15004 өргөдөл, гомдол, санал ирүүлсэн байна. Үүнээс өргөдөл 13537 буюу 90.2 хувь, гомдол 1009 буюу 6.7 хувь, санал 458 буюу 3.0 хувийг тус тус эзэлж байна.</p>		
<p>2.8. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10. Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан хууль ёсны шаардлага, шийдвэрийг хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан түүний дагуу холбогдох арга хэмжээг заавал авч, хариуг хугацаанд нь өгөх үүрэгтэй.</p>	<p>2.8.1 Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, хугацаатай албан бичгийн биелэлтийг заасан хугацаанд нь хүргүүлэх, зөвлөмжтэй холбогдуулан зохион байгуулалтын арга хэмжээ авах.</p>	<p>Авлигатай тэмцэх газраас 2019 онд зөрчил арилгуулах зөвлөмж 1, хугацаатай 6 албан бичиг ирсэн бөгөөд зөвлөмжийн дагуу зөрчлийг арилган, хугацаатай 6 бичгийг тус тус хугацаанд нь гарган, нэгтгэн хүргүүлэв.</p>	<p>100.0</p>	<p>100.0</p>
	<p>2.8.2. Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах мэдэгдэл болон хууль, журмын хүрээнд хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар ирүүлсэн албан бичгийн биелэлтийг</p>	<p>Тайлант онд Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах мэдэгдэл болон хууль, журмын хүрээнд хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар албан бичиг, мэдэгдэл ирүүлсэн болно.</p>	<p>100.0</p>	<p>100.0</p>

		тус тус шийдвэрлэн хугацаанд нь хүргүүлэх.			
2.9. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10. Төрийн байгууллага, албан тушаалтан авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзсэн тушаал, шийдвэр, журам, дүрмийг Авлигатай тэмцэх газраас өгсөн саналын дагуу дахин хянаж хүчингүй болгох буюу өөрчилнө.	2.9.1. Төрийн байгууллага, албан тушаалтан авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзсэн тушаал, шийдвэр, журам, дүрмийг Авлигатай тэмцэх газраас өгсөн саналын дагуу дахин хянаж, хүчингүй болгох буюу өөрчилнө.	Тайлант онд АТГ-аас авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн байгууллагын дотоод үйл ажиллагаанд болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгуулах албан бичиг, мэдэгдэл ирээгүй болно.	100.0	100.0	
	2.9.2. Сумдын Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын даргын тушаал, шийдвэрийн үндэслэлийг хянаж, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзсэн тушаал, шийдвэр, журам, дүрмийг хүчингүй болгуулах.	Хууль, эрх зүйн хэлтсээс сумдын Засаг дарга болон Тамгын газрын даргын тушаал шийдвэрийн үндэслэлийг хуваарь гарган хянаж хэвшсэн. 2019 оны 12 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар 19 сумын 1246 шийдвэрийн тус тус хууль, эрх зүйн үндэслэл, архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг хянаж, зөрчлийг арилгуулан, арга зүйн зөвлөмж, дүгнэлт хүргүүлэн ажиллав. Уг шийдвэрүүдэд авлига гарах нөхцөл бүрдүүлсэн гэх шийдвэр, журам, дүрэм байхгүй гараагүй болно.	100.0	100.0	
2.10. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10-22 дугаар зүйлүүдэд заасан албан тушаалтанд тавигдах хориглолт хязгаарлалтыг	2.10.1. Албан тушаалтны ХАСУМ-ийг хянасан дүгнэлтийг үндэслэн албан тушаалтанд зөвлөмж чиглэл хүргүүлж ажиллах.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5, 23.6 дахь хэсэгт заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 1-ны өдрийн байдлаар аймгийн Засаг дарга болон аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаас нийт 25, 19 сумын 21, агентлагын 29 нийт 75 албан тушаалтны нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг эрх бүхий газарт хүргүүлж, албан үүргийг хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэхийг хянуулсны дараа тухайн албан тушаалд томилох үйл	100.0	100.0	

	хэрэгжүүлж ажиллах.		ажиллагаа хэвшээд байна. Сумд болон аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний газар, хэлтэс, албадуудад аймгийн Засаг даргын 2018 оны 02 дугаар “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” албан даалгавар хүргүүлж, жил бүр үр дүнг тооцож байна.		
		2.10.2. Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд /шинэчлэн болон шинээр томилогдсон албан тушаалтнуудад/ үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө өгөх асуудлыг хариуцах.	Хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн чиглэлээр 19 сумын Засаг даргын Тамгын газар, 21 агентлаг, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагын удирдах албан тушаалтнуудыг арга зүйгээр хангаж, нийт 330 мэдүүлэг гаргагч нарын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулах ажлыг зохион байгуулав. Мэдүүлгийг засваргүй, бүрэн гүйцэд бөглөгдсөн, хугацаандаа өгсөн эсэхэд хяналт тавьж давхардсан тоогоор 60 гаруй зөрчлийг мэдүүлэгч буюу тухайн албан тушаалтанд буцааж, зохих журмын дагуу гаргуулсан.	70.0	70.0
		2.10.3. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, цахим системд бүртгэх зэрэг хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах. Сум, байгууллагуудад зөвлөмж хүргүүлэх.	Байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйл заалтын хэрэгжилтэд шалгалт явуулж, 492 тайлбар, мэдэгдлийн хуудсыг цахим системд нөхөн оруулж, биелэлт хангалтгүй сумдын Засаг дарга болон байгууллагын удирдах албан тушаалтнуудад зөрчил арилгах талаар албан бичгээр зөвлөмжийг хүргүүлэн ажиллав.	30.0	30.0
ДУНДАЖ ОНОО				93.8	93.8
Гурав. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд					
3	3.1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 1 дүгээр зорилт: Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх,	3.1.1. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан	Тайлант онд аймгийн Засаг дарга болон аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаас 25, 19 сумын 21, 21 агентлагын 29 нийт 75 албан тушаалтны нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг эрх бүхий байгууллагын хянасан дүгнэлтийг тус тус сум, байгууллагынхаа цахим хуудсанд байршуулсан. Аймгийн Засаг дарга болон Тамгын газрын даргын	100.0	100.0

<p>төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх.</p>	<p>мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг тухай бүрд олон нийтэд ил тод болгох.</p>	<p>хянуулсан 25 дүгнэлтийг аймгийн цахим хуудас www.uvurkhangai.mn сайтны “Ил тод” цэсний “Авлига, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” хэсэгт байршуулж, олон нийтэд ил тод болгоод байна.</p>		
	<p>3.1.2. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэгт хавсаргаж хүргүүлэх баримт бичгийн жагсаалтад Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн тогтоол, дүгнэлтийг оруулах.</p>	<p>Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэгт хавсаргаж хүргүүлэх баримт бичгийн жагсаалтад Төрийн албаны салбар зөвлөлийн 5 тогтоол, дүгнэлтийг хүргүүлэв.</p>	100.0	100.0
<p>3.2. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2 дугаар зорилт: Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах.</p>	<p>3.2.1. Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, цахим үйлчилгээг бэхжүүлэх.</p>	<p>Тус аймгийн 17 сум, аймгийн Засаг даргын дэргэдэх 15 газар, хэлтсүүд албаны мэдээ, мэдээллийг дамжуулж ашиглаж байна. Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр аймгийн Засаг даргын Тамгын газар, сумдын Засаг даргын Тамгын газарт албаны имэйл нэвтрүүлж, төрийн байгууллагууд үйл ажиллагаандаа ашиглаж байна.</p> <p>Азийн хөгжлийн банкны төслөөр 2019 онд Өлзийт, Баруунбаян-Улаан, Хужирт, Зүүнбаян-Улаан, Баян-Өндөр сумдын иргэний бүртгэлийн ажилтнуудыг онлайн сүлжээнд холбож, бүртгэлийн үйлчилгээг иргэдэд газар дээр нь чирэгдэлгүй, шуурхай үзүүлэх боломжийг бүрдүүлэв. Аймгийн хэмжээнд 2019 оны 10 дугаар сарын байдлаар 12 сум буюу нийт сумдын 63.5 хувь нь бүртгэлийн онлайн сүлжээнд холбогдоод байна. Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн эх нотлох баримт тус бүр 100 хувь цахимжив. Улсын бүртгэлийн үйлчилгээний хураамжийг ebarimt аппликейшн ашиглан төлбөр төлөх боломжтой болгов. Мөн улсын бүртгэлийн 18 төрлийн үйлчилгээ, 20 төрлийн лавлагааны төлбөрийг ebarimt ашиглан төлөх боломж бүрдэж, УБЕГазрын BURTGEL.MN сайтаар цахим</p>	70.0	70.0

			архивын програмаас лавлагаа олгох, 14 төрлийн лавлагааг цахимаар хүлээн авах нөхцөл тус тус бүрдээд байна.		
	3.3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 3 дугаар зорилт: Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх.	3.3.1. Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын одоогийн тогтолцоонд дүн шинжилгээ хийж, оновчтой бүтцийг бий болгох санал боловсруулах.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагч, санхүүгийн ажилтнуудтай “Төсвийн сахилга хариуцлагын гэрээ”-г 4 жилийн хугацаатай байгуулав. Аймгийн Засаг даргын 2019 оны “Төсвийн сахилга, хариуцлагын тухай” 02 дугаар албан даалгавраар, бүх шатны төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт төсвийг үр ашигтай зарцуулах, хэмнэлтийг бий болгох, өр, авлагагүй ажиллахыг үүрэг болгосон. Мөн төсөв, санхүүгийн сахилга бат, хариуцлага, санхүүгийн жилийн эцсийн тайлангийн аудитын дүгнэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын 2019 оны “Хариуцлага тооцох, шагнал урамшуулал олгох тухай” А/376 дугаар захирамжаар 19 сумын төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч, санхүүгийн ажилтан, аймгийн орон нутгийн төсөвт 17 байгууллагын шууд захирагч, нягтлан бодогч, санхүүгийн мэргэжилтнүүдэд үндсэн цалингийн 0.5-1.0 сарын урамшуулал олгохоор, Шилэн дансны тухай хуулийн мэдээллийг мэдээлээгүй байгууллага, сумын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт сануулах арга хэмжээг тооцон ажилласан	100.0	100.0
		3.3.2. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг шилэн дансны “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах.	Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт болон зарцуулалтыг шилэн дансны сайтад сар бүр мэдээлэн ажиллаж байна.	100.0	100.0
		3.3.3. Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулан шийдвэрийн ил тод нээлттэй	Аймгийн орон нутгийн хөгжлийн санд 2019 онд 6680.4 сая төгрөг батлагдсанаас Орон нутгийн хөгжлийн сангаас 5601.1 сая төгрөг, ТА-3 төслөөс 1079.3 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөгдсөн. Үүнээс 11 дүгээр сарын	100.0	100.0

	байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх.	байдлаар Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн орон нутгийн хөгжлийн санд 4896.6 сая төгрөг хуваарилагдахаас 4601.6 сая төгрөг хуваарилагдан 295.0 сая төгрөг дутуу санхүүжигдсэн байна. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт 3996.2 сая төгрөг төлөвлөгдсөнөөс мал эмнэлэгийн үйлчилгээнд 439.4 сая төгрөг, Арвайхээр хот тохижилт үйлчилгээнд 43.3 сая төгрөг, хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд 3513.3 сая төгрөг төлөвлөгдөж мал эмнэлэгийн үйлчилгээнд 100%, хот тохижилт үйлчилгээнд 100% олгосон бөгөөд хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний 16 ажил хэрэгжүүлэхээс 15 ажлын гэрээ хийгдэж нийт 2309.8 сая төгрөгийн санхүүжилт олгоод байна. Мэдээллийг аймгийн цахим хуудас байршуулсан.		
	3.3.4. Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулах, төсвийн төсөлд олон нийтийн саналыг тусгах.	Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т заасан төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх гэж заасны дагуу орон нутгийн төсвийн байгууллага, бусад хамаарах салбарын төсвийн төслийн саналыг нэгтгэн авч Сангийн яаманд хүргүүлсэн. Төсвийн төслийг боловсруулахдаа дээд шатны байгууллага болох Сангийн яамнаас ирүүлсэн удирдамжийн дагуу аймаг, сумын төсвийн байгууллагад төсвийн төсөл хийх аргачлал, зааврын хамт хүргүүлж төсвийн саналыг боловсруулан авч хэвшсэн болно. Орон нутгийн төсвийн төсөлд олон нийтийн саналыг тусгаснаар төсөв үндэслэлтэй хийгдэж, иргэдийн саналыг тусгасан, хэрэгцээ шаардлагад үндэслэсэн төсөв бий болсон.	100.0	100.0
3.4. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4 дүгээр зорилт: Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх.	3.4.1. Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах, цаашид тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулж хэвшүүлэх.	2019 онд улс, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, авто замын сан, төсөвт байгууллагуудын захиалгаар нийт 65.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 87 төсөл, арга хэмжээ төлөвлөж, 2019 оны 11 дүгээр сарын байдлаар бүрэн зохион байгуулж дууссан байна. Тендер шалгаруулалтын босго үнээс хамааруулан 71.5 хувийг нээлттэй тендер шалгаруулалт, 28.5 хувийг тендер шалгаруулалтын онцгой журам болох харьцуулалтын аргаар 100 хувь цахим хэлбэрээр зохион байгууллаа.	100.0	30.0

	3.4.2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах.	Тухайн онд зохион байгуулагдах худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендер шалгаруулалтын үр дүн болон хяналт, шалгалтын байгууллагуудын тайлан, дүгнэлт зэрэг 90 орчим мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим сайт tender.gov.mn-д нийтэлж хэвшсэн байна.	100.0	70.0
	3.4.3. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг цахим хуудсанд байршуулж мэдээлэх.	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх 50 гаруй мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим сайт tender.gov.mn-д тендер шалгаруулалтын үр дүнг мэдээлсэн байна.	70.0	70.0
Дундаж оноо			94.0	84.0
Нийт хувь			93.9	90.6

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС